



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 295

Улаанбаатар хот

Г “Голомт банк” ХХК-д кастодианы
Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай Т

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, Банкны тухай хуулийн 6.2, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 85/A-106 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Голомт банк” ХХК-д үнэт цаасны зах зээлд кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллахыг “Голомт банк” ХХК /Г.Ганболд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000323